



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ БҮСИЙН ОНОШИЛГОО, ЭМЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2025 оны 05 сарын 20 өдөр

Дугаар 2/17

Арвайхээр сум

Чанарын менежментийн тогтолцооны баримт бичгүүдийг батлах тухай


Эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.10.1 дэх заалт, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Өвөрхангай аймаг дахь Бүсийн оношилгоо эмчилгээний төвд чанарын менежментийн тогтолцоо MNS ISO 9001:2015 стандартыг нэвтрүүлэх чанарын гарын авлагыг нэгдүгээр, "Чанарын менежментийн тогтолцоо"-ны баримт бичгийн жагсаалтыг хоёрдугаар, Менежментийн тогтолцооны баримт бичгийн "А, В, С мастер хуудас"-ыг (бүртгэл хяналтын жагсаалт) гуравдугаар хавсралтаар тус тус баталж 2025 оны 06 дугаар сарын 01 өдрөөс эхлэн мөрдсүгэй.

2. "Чанарын менежментийн тогтолцоо"-ны баримт бичиг, дүрэм журмыг үйл ажиллагаандаа баримтлан биелэлтэд хяналт тавьж ажиллахыг "Чанарын менежментийн тогтолцоо"-ны менежер (Д.Аззаяа)-д, удирдах, үндсэн, дэмжих багийн ахлагч нар, тасаг албадын дарга нарт тус тус үүрэг болгосугай

3. Холбогдох баримт бичгүүдийг мөрдлөг болгон хэвшүүлж ажиллахыг хяналтын зөвлөх Д.Болормаа, З.Цэрэнбат, нийт ажилчдад үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ



Г. ДАШЖАНЦАН